

## ТАНИЛЦУУЛГА

*Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай  
хуульд өөрчлөлт оруулах тухай*

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд иргэн, өрх, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тусгасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, иргэдийн эцсийн хэрэглээндээ төлдөг нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулж, аж ахуйн нэгжүүдэд үүсгэж буй хүндрэлийг нэг мөр шийдвэрлэх шаардлага тулгарч буйг харгалзан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 8 дугаар зүйлийн 8.5, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” гэж заасан байна.

Тус татварын шинэчлэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ыг Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлтөөр тусгаж буй тул Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

---oOo---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

### **МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т” гэснийг “Татварын ерөнхий хуульд” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

### *Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд иргэн, өрх, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тусгасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, иргэдийн эцсийн хэрэглээндээ төлдөг нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулж, аж ахуйн нэгжүүдэд үүсгэж буй хүндрэлийг нэг мөр шийдвэрлэх шаардлага тулгарч буйг харгалзан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсэгт “Нотариатч нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.21-д заасан хэрэглэгчийн системтэй байх бөгөөд үзүүлсэн үйлчилгээ, үйлчилгээний хөлс, тээврийн зардлын хэмжээг тусгасан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.14-т заасан төлбөрийн баримтыг үйлчлүүлэгчид олгож, төлбөрийн баримтын мэдээллийг гурав хоногийн дотор багтаан борлуулалтын нэгдсэн системд илгээнэ” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.12 дахь заалтад “Монгол Улсад байнга оршин суугч татвар төлөгчөөр татварын албанд бүртгүүлж, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.21-д заасан хэрэглэгчийн систем ашиглах, хуульд заасан хугацаанд татварын тайлангаа харьяалах татварын албанд гаргаж өгөх” гэж тус тус заасан.

Татварын шинэчлэлийн хүрээнд Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.52 болон 6.1.57-д “хэрэглэгчийн систем” болон “төлбөрийн баримт” гэсэн нэр томъёоны тодорхойлолтуудыг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд нэмж тусгаж буй тул дээрх зохицуулалтуудыг энэ хуулиар зохицуулах нь зүйтэй байна.

Иймд Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8, 21 дүгээр зүйлийн 21.2.12 дахь заалтад заасан “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.21-д” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 6.1.52-т” гэж, 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.14-т” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 6.1.57-д” гэж тус тус өөрчлөв.

---oOo---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

### НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.2.12 дахь заалтын “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.21-д” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 6.1.52-т” гэж, 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.14-т” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 6.1.57-д” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

### *Хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд иргэн, өрх, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тусгасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, иргэдийн эцсийн хэрэглээндээ төлдөг нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулж, аж ахуйн нэгжүүдэд үүсгэж буй хүндрэлийг нэг мөр шийдвэрлэх шаардлага тулгарч буйг харгалзан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Хотын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Албан татвар ногдуулах хугацааг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай<sup>[5]</sup> хуулийн 10.2-т заасан журмын дагуу тооцно” гэж, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт “Албан татвар суутган төлөгч нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан хэрэглэгчийн системтэй байх бөгөөд мөн хуулийн 17.3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ” гэж тус тус заажээ.

Татварын шинэчлэлийн хүрээнд Нэмэгдсэн өртгийн албан татварын 10.2-т заасан татварын ногдуулах хугацаатай холбоотой зохицуулалтыг шинэчилсэн найруулгын 9 дүгээр зүйлд тусгасан. Мөн Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.52-т “хэрэглэгчийн систем” гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг тус хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд нэмж тусгаж буй тул энэхүү зохицуулалтыг тус хуулиар зохицуулах нь зүйтэй байна.

Иймд Хотын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “10.2-т заасан журмын” гэснийг “9 дүгээр зүйлд заасны” гэж, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” гэснийг “Татварын ерөнхий” гэж тус тус өөрчлөв.

---oOo---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

### ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хотын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “10.2-т заасан журмын” гэснийг “9 дүгээр зүйлд заасны” гэж, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” гэснийг “Татварын ерөнхий” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг